




ЛАНДШАФТ ДИЗАЙН

# ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО ХЭРЭГЦЭЭГЭЭ ТОДОРХОЙЛЖ, МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАН ГАДНА ОРЧНЫ ДИЗАЙНЫ ТӨЛӨВЛӨЛТ ГАРГАХ

Хийх алхам

1. Асуудал хэрэгцээгээ тодорхойлох
2. Мэдээлэл цуглуулах
3. Төлөвлөлт зурах таних тэмдгүүдийг таньж мэдэх
4. Таних тэмдгүүдээ ашиглан гадна орчны төлөвлөлт зурах

# ЗУРГИЙГ АЖИГЛАН БАРИЛГЫН ГАДНА ОРЧИНД ЮУ ЮУ БАЙГААГ НЭРЛЭЭРЭЙ.



- Зүлэг
- Мод, бут сөөг
- Явган зам
- Саравч
- Амралтын сандал
- Хиймэл нуур
- Усан оргилуур

# 1. АСУУДАЛ ХЭРЭГЦЭЭГЭЭ ТОДОРХОЙЛОХ

Хүүхдүүдээ та нарын амьдарч байгаа байшин, гэрийн гадна талд ямар тохижилт хийх шаардлагатай байгаагаа гэр бүлийнхэнтэйгээ ярилцаад хэрэгцээгээ тодорхойлоорой.

-Барилгын гадна талын орон зайн тохижилт, амрах талбайн төлөвлөлт хийхийн ач холбогдол юу вэ?

-Барилгын гадна талын орон зайд амрах талбайн төлөвлөлтийн шийдлийг хэр оновчтой хийсэн байна вэ?

-Гадна орчны төлөвлөлтийн давуу тал сул тал, сайжруулахтай холбоотой санал юу байна вэ?

## 2.МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ СУДАЛГАА ХИЙХ

Судалгаа гэж юу вэ?

Судалгаа бол аливаа юмс үзэгдлийн тухай шинэ мэдлэгийг шинжлэх ухааны үндэстэйгээр олж авах үйл явц юм.

Төлөвлөлт гэж юу вэ?

Төлөвлөлт нь хүсч байгаа үр дүн, зорилгодоо хүрэх арга зам буюу тухай зорилгын эхний үеэс биелэх хүртэл хугацаанд хийх бүхий л үйл ажиллагааг тусгасан баримт бичиг юм.

# БАРИЛГЫН ДИЗАЙН



- Экстерьер-Барилгын хэлбэр хийц гадна талын дизайн.
- Интерьер-Барилгын дотор талын дизайн
- Ландшафт-Барилгын гадна орчны дизайн

# МЭДЭЭЛЭЛ

Хүмүүс бидний хүрээлэн байгаа орчин маш хурдацтай өөрчлөгдөн эд юмсын хэлбэр дүрс улам боловсронгуй болж, шинэ шинэ хэрэгсэл эд юмсыг хэрэглэх болсон.

Өөрийн оюун, уран сайхны сэтгэхүйгээр хамгийн оновчтой зөв хэлбэрийг зохион бүтээх хүмүүсийн үйл ажиллагаа улам идэвхжэж бие даасан мэргэжил болсон нь дизайн буюу уран сайхны зохион бүтээлт билээ.

Дизайн XX зууны эхэн үеэс эрчимтэй хөгжсөн урлаг бөгөөд манай оронд дизайн урлаг хөгжсөнөөр нийгмийн харилцаа, хүмүүсийн амьдралын төлөв байдал хот тосгодын нүүр царайг өөрчлөх хүчин зүйл болж байна.

Дизайн урлаг бидний хүрээлэн буй орчинд байгаа боловсронгуй бус дутагдалтай хэлбэр, дүрс болон нийтийн таашаалд шүүмжлэлттэй ханддаг. Барилга байгууламжийн гадна талын бүхий л эд юмсыг нэгтгэн нэгэн цогц шийдэлтэй загварчлахыг экстерьер дизайн гэдэг ба энэ нь барилга байгууламжийн гадна тал гадна хана, гадна орчин гэсэн утга санааг илэрхийлсэн англи үг юм.

Ландшафт дизайн нь барилга байгууламжийн орчин тойрны юмсын хэлбэрийн шинэлэг байдал, өнгийн зохицол, зүй зохистой харьцаа гэсэн үг. Барилга байгууламжийн орчин тойрны байгалийн болон хүний гараар бүтээгдсэн юмсын шинж чанарын уялдаа холбоо зүй зохистой харьцаа гэж тайлбарлажээ.


# СУДАЛГАА

1. Амины орон сууцныхаа гадна талын орон зайн тохижилт, амрах талбайн төлөвлөлтийг хэрхэн хийх талаар гэр бүлийн гишүүдтэйгээ ярилцаж тэдний саналыг сонсож, тэмдэглэл хөтлөх байдлаар анхан шатны судалгаагаа хийнэ.
2. Амины орон сууцны гадна талын орон зайн тохижилт, амрах талбайн төлөвлөлтийн орчин үеийн шийдлүүдтэй холбоотой ном гарын авлага, баримт материал, зураг цуглуулна.
3. Судалгааны материалууд, мэдээллүүдээ харьцуулан дүн шинэжилгээ хийнэ

# ЛАНДШАФТ ДИЗАЙН БОЛОН ГАДНА ОРЧНЫ ДИЗАЙНЫ ШИНЭ САНАА ШИЙДЭЛ ГАРГАХДАА




- Хүний амрах орчны судалгаа түүний үр дүнд тулгуурлан шийдэл гаргах
- Гадна талбайн орчны хэмжээг нарийн тооцох
- Төлөвлөлтөд байх зүйлсийг жагсаан бичих /ногоон байгууламж-зүлэг, цэцэг мод, амрах талбайн хэсэг-сандаал, ширээ, сүүдрэвч, хиймэл цөөрөм, нуур, усан оргилуур гэх мэт/
- Гадна орчны төлөвлөлтийн байрлалын зураг зурах
- Орчин үеийн дизайны шийдлийг хангаж байх
- Тав тухтай эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлж байх
- Тогтвортой хөгжлийн үзэл санааг дэмжиж байх

# БАРИЛГЫН ГАДНА ТАЛЫН ОРОН ЗАЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ПЛАН ЗУРГИЙГ ЗУРАХАД ХЭРЭГЛЭГДЭХ ДҮРСЛЭЛ БУЮУ ТАНИХ ТЭМДЭГҮҮД



Мод, бут, сөөг, өвс  
Усан оргилуур  
Талбай  
Сандал ширээ  
Хиймэл нуур,  
цөөрөм, усан сан


# ТАНИХ ТЭМДГҮҮДЭЭ АШИГЛАН ГАДНА ОРЧНЫ ТӨЛӨВЛӨЛТИЙН ПЛАН ЗУРАГ ЗУРАХ





ДИЗАЙНЫ АНХНЫ САНААГАА ГЭР  
БҮЛИЙНХЭН БОЛОН АНГИЙН ХАМТ  
ОЛОНДОО ТАНИЛЦУУЛАН ХЭЛЭЛЦҮҮЛЖ



# ГАДНА ОРЧНЫ ТӨЛӨВЛӨЛТ ЗУРАХ











# БИЕ ДААН ХИЙХ АЖИЛ

- Өөрсдийн цуглуулсан мэдээлэл, хийсэн судалгаан дээрээ үндэслэн гадна орчны дизайны шинэ санаа шийдэл гарган зураарай